

ГАЗАРЗҮЙ БА ГЕОМОРФОЛОГ


ХЭРЛЭНГИЙН ИХ ТОХОЙРЛЫН МОРФОСТРУКТУР

Я.БОЛД, Х.УЛАМБАДРАХ

Монгол Улсын Үх Сургууль

Геологийн арга нь чулуулгүүдийн литологи, петрографийн шинж тэмдгээр, гео-морфологийн арга нь голын сүлжээний дурс, усны хагалбарын дүрсүүдийн агаар, сансарын зураг дээр дүрслэгдэх байдлаас тайлалт хийх аргууд юм. Сансарын зургийн

тайлалт хийснээр Хэрлэнгийн их тохойрлын төв хэсэгт голын сүлжээний дурс, усны хагалбарын дурс, чулуулгийн геологийн тогтоц, литологи-петрографийн найрлагаараа ялгагдах цагирган тогтцууд илэрснийг 1-р



1-р зур. Хэрлэнгийн их тохойрлын морфоструктүүр масштаб 1:50 000.

(Х. Уламбадрах, Я. Болд, 1998)

1-Голын гульдралууд, 2-5: Хагарлуд: 2-грабен хязгаарлагч, 3-блок хязгаарлагч, 4-тод мэдэгдэж байгаа, 5-таамагласан, 6-8: Цагирган тогтоцууд: 6-голын сүлжээний дүрсээр, 7-усны хагалбарын дүрсээр, 8-литологи-петрографийн нийрлагаар, 9-Аймгийн (а) ба сумын (б) төв, 10- Хэрлэнгийн их тохойрол (Хэрлэн голын хөндий)

зургаар харуулав.

Цагирган тогтцыг хэмжээгээр нь 150 км-ээс их хөндлөн огтлолтой макро, 150 км хүртэл хөндлөн огтлолтой мезо, 10-15 км хөндлөн огтлолтой микроструктуур гэж ангилдаг. Энэ ангиллаас Хэрлэнгийн их тохойролд мезо, микроструктуурүүд ихээхэн тархалттай байгаа юм.

Шугаман структуурээс чулуулаг бүрхүүлийн морфоструктуурийг илэр хийлэгч нь хагарал учраас цагирган тогтцыг янз бүрээр хэрчин хэлбэр дүрсийг нь алдагдуулсан, тасалсан, өргөгдөл, грабен структуурүүдэд өөрчилсөн байх нь зураг дээр дүрслэгдсэн.

Цагирган структуурийн гарал үүсэл, хөгжлийн онцлогт шинжилгээ хийж үзэхэд ашигт малтмалын ордын байршлыг хянаж байгаа нь тогтоогдсон байна. Энэ нь шавартын хөндий орчмын морфоструктуурийн зураг дээр нарийн ажиглагдав.

Неогены галваас хойш орчин үеийн газрын гадаргуу хүргэл дунджаар 250-340м хурдас, чулуулаг зөөгдсөнийг денудаци хэрчигдлийн гүний зураг зохиосноор нэгэнтээ тогтоосон билээ.

Өнгөрснийг сэргээн босгохтой зэрэгцээд ирээдүйд ямар болохыг урьдчилан боловсруулах нь аливаа

шинжлэх ухааны гол зорилгын нэг байdag. Үүнтэй холбогдуулан бид Шавартын хөндий орчмын талбайн хамгийн өндөр (H_{max}), хамгийн нам (H_{min}), дундаж өндрийн (H_{dun}) зураг зохиосноо ашиглаж маш энгийн, харьцангуйгаар хэдий хэр хугацааны дараа тэгширлийн гадарга болох талаар гаргахыг оролдоо. Харин энэ асуудалд тектоник үйлчлэл болон петрофизикийн нэлэөллийг эс тооцсон .

Шавартын хөндий ойролцоогоор 26 сая жилийн дараа тэгшрэлийн гадарга болж болох бөгөөд одоогийн дөрөвдөгчийн хурдсаар хучигдсан талбайнуудад тухайлбал, Дэлгэрханаы грабен, Мөрөн голын хөндий г.м газруудад 320 м (дунджаар) хурдас нэмэгдэн тэгшрэлийн гадаргын хурдас болох юм. Энэ тооцоог гаргахдаа 1300 м-т оорших орчин үеийн эрозийн базисийн өндрийг анхаарч үзсэнийг тэмдэглэе.

Ашигт малтмалын үндсэн ордын элэгдэлт, шороон ордын үүсэл нь үүнтэй нягт холбогдотой асуудал бөгөөд цаашид нэмэлт судалгаа хийн нарийвчлах шаардлагатай нь зайлшгүй юм.

Зохиол

1. Я. Болд. Геоморфологийн үндэс ба судалгаа, Улаанбаатар, 1987